

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Гаалийн улсын байцаагч
Баярсайхан овогтой Ганбатын
2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 4. “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ”							
1.	Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хяналт тавьсан байдал	Төсвийн хэмнэлт хувиар, Үүссэн өглөг, авлага төгрөгөөр	100%	1. Байгууллагын төсвийн хуваарийг боловсруулан батлуулж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлийг баримтлан төсвийг үр ашигтай зарцуулан ажилласан байна. (I-IV улирал)	1. Гаалийн байгууллагын 2024 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг оновчтой төлөвлөн Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ний өдрийн 01/2685 тоот албан бичгээр дээд шатны байгууллагад хүргүүлж батлуулсан. Гаалийн ерөнхий газар нь 2024 онд 31,238.0 сая төгрөгийн урсгал санхүүжилт, 15,285.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт нийт 46,523.2 сая төгрөг батлагдсанаас 2024 оны 11 сарын 30-ны байдлаар 14,184.2 сая төгрөгийн урсгал зардлын санхүүжилт, 15,270.2 сая төгрөг хөрөнгө оруулалтын санхүүжилт 12,177.8 сая төгрөг, нийт 29,454.4 сая төгрөгөөр төсөв батлагдсан бөгөөд урсгал зардлын гүйцэтгэлээр 9,308.2 сая төгрөгийн буюу 65.6 хувийн	2024.01.01-2024.12.31	100

				гүйцэтгэлтэй, хөрөнгө оруулалтын санхүүжилт 1,870.4 сая төгрөгийн буюу 12.2 хувийн гүйцэтгэлтэй, нийт 15,718.8 сая төгрөгийн буюу 53.4 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Гаалийн ерөнхий газар нь 2024 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар төсвийг үр ашигтай зарцуулж урсгал төсвийн санхүүжилтээс 4,875.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 13,399.8 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. 2. 2024 онд гаалийн байгууллага Урсгал санхүүжилтээр 137.5 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 15.3 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсаныг Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодод хуваарилан ажиллаж байна. 2024 онд Харьяа гаалийн газар, хороодод 106.3 тэрбум төгрөгийг хуваарилан, гүйцэтгэлд батлагдсан төсвийн гүйцэтгэлийн мэдээний маягтаар хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд Урсгал санхүүжилтээр 114.6 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 15.3 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсанаас харьяа гаалийн газар, хороодод 100.4 тэрбум төгрөгийн урсгалт санхүүжилт хуваарилагдсан. Тайлант хугацаанд Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороод 96.6 тэрбум төгрөгийн буюу 84.3 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.		
--	--	--	--	---	--	--

2	Байгууллагын санхүүгийн тайланг гаргах, удирдлагыг мэдээллээр хангасан байдал, аудит, хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	1. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж баталгаажуулсан байна 2. Аудит, хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг тайлагнасан байна	1. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, баталгаажуулан, удирдлагыг мэдээллээр бүрэн хангаж ажилласан. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газраар шалгуулж Өөрчлөлтгүй санал дүгнэлт авсан. 2024 оны 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг гаргаж баталгаажуулсан. 2. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар 2 зөвлөмж авсан. • Аудитын зөвлөмжийн дагуу 2024 оны эхний 6 сарын байдлаар 282 ширхэг гүйлгээгээр 1,412.1 сая төгрөгийн гүйлгээг өглөг, урьдчилгаа тооцооны дансаар дамжуулан давхар бичилт хийж нягтлан бодох бүртгэлд тусгаж ажилласан • Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж үргүй зардал гаргахгүй ажилласан. Сангийн сайдын 2024 оны СХШХ/03 дугаартай удирдамжийн дагуу 2022, 2023 оны санхүүгийн баримтад хийгдсэн шалгалтад санхүүгийн холбогдолтой баримтуудыг бүрэн хамруулсан. Шалгалтаар урсгал үйл ажиллагаанд акт, албан шаардлага, зөвлөмж аваагүй. Үндэсний аудитын газраас хийгдсэн 2024 оны завсрын аудитад санхүүгийн баримтыг хамруулж ажилласан.	2024.01.01 – 2024.12.31	85
3	Бараа, ажил, үйлчилгээ худалдан	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Худалдан авах ажиллагааг хууль	- Гаалийн ерөнхий газрын 2024 оны худалдан авах ажиллагааны	2024.01.01 –	100

	авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн			тогтоомжийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу ил тод нээлттэй зохион байгуулсан байна.	төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эрэлч нохойн сургалтын төвийн албаны эрэлч нохдыг зориулалтын хоолоор хангах харьцуулалттай тендер шалгаруулалтыг үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж хууль журамд заасны дагуу худалдан авалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр Аз Болор Мөнх Трейд ХХК-г шалгаруулж гэрээний гүйцэтгэл 100 хувь биелүүлсэн. Тус худалдан авалттай холбоотой гомдол санал гараагүй болно. - Гаалийн байгууллагын 2023 оны үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос Сангийн сайдын 234 дүгээр тушаалаар 572.9 сая төгрөгийг зарцуулах шийдвэр гарсны дагуу Гаалийн ерөнхий газрын даргын А/461 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж “Зарим гаалийн газар, хороодын тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл /Улсын хэмжээнд/” худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Уг тендер шалгаруулалтын Багц №1-д Грандмакс ХХК, Багц №2-д Ай Ти Зон ХХК, Багц №3-д Сүүхүнгий ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн дээрх худалдан авалтын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны Цахим дэлгүүрээс Ерөнхий гэрээний дагуу 4 ширхэг ухаалаг самбарыг Саммит Компьютер Технологи ХХК-иас худалдан авсан.	2024.12.31	
4	Албан хаагчдын нийтлэг баталгаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Төрийн албан хаагчийн нийтлэг	2024 оны 03 дугаар сарын 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын	2024.01.01	100

	цалин хөлс, урамшуулал, илүү цаг, тэтгэмж гэх мэт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал			баталгааг хангах чиглэлээр цалин хөлсний тооцоо судалгааг гаргаж харьяа гаалийн газар, хороодод цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг хуваарилах	цалингийн шатлалд өөрчлөлт орж төрийн тусгай албан хаагчдын үндсэн цалин 10%-иар, төрийн үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалин 20%-иар тус тус өссөн. Албан тушаалын цалингийн хэмжээ нэмэгдсэнээр гаалийн байгууллагын албан хаагчдын үндсэн цалин 2022 оныхоос 763.6 мянган төгрөгөөр, 2023.06.30-ны өдрийн байдлаарх үндсэн цалингаас 449.6 мянган төгрөгөөр, 2024.03.31-ний өдрийн байдлаарх үндсэн цалингаас 157.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/193 тоот тушаалаар нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоож Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газруудад ажиллаж байгаа албан хоол унааны мөнгийг өдөрт 21.5 мянган төгрөг, сард 473.0 төгрөгөөр, бусад орон нутаг дахь харьяа гаалийн газар, хороодын хоол, унааны мөнгийг өдөрт 18.5 мянган төгрөг, сард 407.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан. Дээрх цалингийн шатлал болон нөхөх төлбөрийн хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотой гаалийн байгууллагын албан хаагчдын цалингийн судалгааг тухай бүрд гарган Харьяа гаалийн газар, хороодын цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлын сар бүрийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан ажилласан.	– 2024.12.31	
--	---	--	--	--	---	-----------------	--

					Дээрх шийдвэрүүдтэй холбоотой 2024 оны батлагдсан төсөв дээр харьяа гаалийн газар, хороодод 8.9 тэрбум төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг нэмж хуваарилсан. Үүнээс: Үндсэн цалин 2.0 тэрбум төгрөг, нэмэгдэл цалин 4.8 тэрбум төгрөг, унаа хоолны хөнгөлөлт 261.1 сая төгрөгийг тус тус нэмж хуваарилсан. Мөн албан хаагчдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр 4 албан хаагчид 2.3 сая төгрөгийн нүүлгэн шилжүүлэлтийн зардал, ар гэрт нь гачигдал гарсан 80 албан хаагч 52.8 сая төгрөг, Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар 14 албан хаагчид 17.9 сая төгрөгийн нэг удаагийн шагнал урамшуулал, нас барсан 8 албан хаагчийн ар гэрт нь 104.5 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг тус тус олгосон. Гаалийн байгууллагын ахмадын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 190.6 сая төгрөгийг зарцуулсан.		
5	Төсөв, санхүүгийн шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд байрших тайлан, мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлэн	ЗГ-ын 2009 оны 143-р тогтоол Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн төсвийн ил тод байдал болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар ханган ажиллаа. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг Гаалийн байгууллагын www.customs.gov.mn цахим хуудасны Ил	2024.01.01 – 2024.12.31	93

				ажилласан байна.	тод байдлын цэс болон шилэн дансны цахим хуудас санхүүгийн мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд нь нийтэд ил тод байхаар байршуулсан болно. 1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт сар бүр 11 мэдээлэл 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт сар бүр 11 мэдээлэл 3. Байгууллагын батлагдсан төсөв жилд нэг удаа 2024.01.10-нд 4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ – тухай бүрд нь 116 мэдээлэл 5. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ – тухай бүрд нь 136 мэдээлэл 6. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт тухай бүрд нь 11 мэдээлэл 7. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг – тухай бүрд нь 120 мэдээлэл 8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр – тухай бүрд нь 106 мэдээлэл		
--	--	--	--	------------------	---	--	--

					9. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл – сар бүр 11 удаагийн мэдээлэл 10. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – жил бүр 2024.01.10-нд 11. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт – жил бүр 2024.01.10-нд 12. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл – тухай бүрд нь 11 мэдээлэл 13. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн – Тухай бүрд нь 11 удаагийн мэдээлэл		
6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн хүрээнд 2024 оны 11 сарын байдлаар 33 сургалт, арга хэмжээний зардалд 98.8 сая төгрөгийн, холбооны суваг ашигласны төлбөрт 7 аж ахуйн нэгжийн 8 гэрээний төлбөр 764.4 сая төгрөг, гаалийн хяналт, шалгалтад ашиглагдах троссон ломбо худалдан авахад улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардлаас 645.9 сая төгрөгийн, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 585.2 сая төгрөгийн гүйлгээг тус тус хийсэн. Гаалийн байгууллагын 2023 оны үндсэн	2024.01.01 – 2024.12.31	100

				үйл ажиллагааны давсан орлогоос Сангийн сайдын 234 дүгээр тушаалаар 572.9 сая төгрөгийг зарцуулах эрх олгосны дагуу Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/461 тоот тушаалаар батлагдсан үнэлгээний хорооны гишүүд Зарим гаалийн газар, хороодын тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл /Улсын хэмжээнд/ нээлттэй тендер шалгаруулалтыг 3 багцтэй зохион байгуулж нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан. 2024 оны үндсэн үйл ажиллагааны дасван орлогын тооцоо судалгааг гаргаж 709.0 сая төгрөгийг зарцуулах хүсэлтийг Гаалийн ерөнхий газрын даргын 2024.10.30-ны 01/4479 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Гаалийн байгууллагын Ахмадын хорооноос 2024 онд ГЕГ-тай хамтран зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу Гаалийн ерөнхий газраас 150.2 сая төгрөг, Ахмадын хорооноос 103.0 сая төгрөг нийт 257.2 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас - "Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөлтөд тусгагдсан зарим ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд ахмадуудыг оролцуулах" зардалд 2.0 сая төгрөг, - "Залуу гаальчидтай ажиллах, ажлын туршлага хуваалцах, мэргэжлийн туслалцаа үзүүлэх" зардалд 2.0 сая төгрөг, - "Сургалтын төвийн залуу сургагч багш нарыг дадлагажуулах" зардалд 2.0 сая төгрөг,	
--	--	--	--	--	--

					- “80 болон түүнээс дээш насны ой тохиож буй ахмадуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулах” зардалд 6.0 сая төгрөг, - ““Монголын цагаан сар” болон “Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан ахмад настангуудад хүндэтгэл үзүүлэх” зардалд 137.7 сая төгрөг, - “Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд зориулж мөнгөн дэмжлэг үзүүлэх” зардалд 16.5 сая төгрөг, - “Ахмад настан өөрөө, эсхүл нөхөр (эхнэр) нас барсан тохиолдолд ар гэрт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох” зардалд 3.3 сая төгрөг, - “Ахмадуудын дунд идэвхитэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” зардалд 3.0 сая төгрөг, - “Ажлын ачаалал, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан шаардлагатай тохиолдолд ахмадын хорооны дарга, хорооны зөвлөлийн гишүүдэд тайланга үндэслэн урамшуулал олгох” зардалд 24.0 сая төгрөг, нийт 196.5 сая төгрөгийг зарцуулаад байна.		
7	Хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,	2024.01.01 – 2024.12.31	100

					үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, болон хуульд нийцүүлэн гаргасан аливаа эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан.		
8	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Тайлант хугацаанд тус нэгжид өгөгдсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд хэрэгжилтийг ханган тайлагнан ажилласан байна.	Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас ирүүлсэн 62 дотоод зурвас, Харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн 87 албан бичиг болон бусад байгууллагаас ирүүлсэн 59 албан бичигт гаалийн байгууллагын дотоод сүлжээгээр удирдлагаас үүрэг даалгавар болон ирснийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн ажилласан.	2024.01.01 – 2024.12.31	93
9	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Ажлын цаг ашиглалт бүрэн байна.	2024 оны 11 сарын байдлаар 229 ажлын өдөр 1832 цаг ажиллахаас 7 хоног ээлжийн амралт биеээр эдэлж 2 удаагийн нийт 14 хоногийн гадаад сургалтад хамрагдаж, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт 3 хоног, Ханги дахь гаалийн газарт 2 хоног, Гашуунсухайт дахь гаалийн газарт 5 хоногийн тус тус албан томилолтоор ажилласан. Илүү ажилласан цаг 162.4 ажилласан. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс зохион байгуулсан мэдээллийн цагт бүрэн хамрагдсан.	2024.01.01 – 2024.12.31	100
10	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж ажилласан. - Эрэлч нохойн хоол худалдан авах харьцуулалттай тендер шалгаруулалтаар нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар томилогдон ажилласан.	2024.01.01 – 2024.12.31	90

					- Цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой тооцоо судалгааг гарган ажилласан - Хоол унааны хөнгөлөлт нэмэгдсэнтэй холбоотой судалгааг гарган ажилласан. - 2023 оны давсан орлогыг зарцуулах судалгаа тооцооллыг гаргасан. Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу Сангийн сайдын 2023 оны 234 дүгээр тушаалаар Гаалийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 572.9 сая төгрөгийг зарцуулах эрх олгогдсон. Журмын 5.1.1-д заасны дагуу Ханги гаалийн газар шинээр байгуулагдсантай холбоотой тавилга, компьютер, тоног төхөөрөмжийг шинээр худалдан авах зардалд 267.9 сая төгрөг, 5.1.3-т заасны дагуу 10 албан хаагчаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийг судлан үзэж эмчилгээний зардал болон орон сууцны дэмжлэг үзүүлэх зардалд 332.9 сая төгрөгийг зарцуулах судалгаа тооцоо гаргасан.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Сургалтад хамрагдсан байна.	Гаалийн ерөнхий газраас зохион байгуулагддаг 7 хоног бүрийн мэдээллийн цагт бүрэн хамрагддаг. БНХАУ-ын Хөх хотод Монголын хил дамнасан хамтын ажиллагааны бүтээн байгуулалт сэдэвт сургалтад хамрагдсан	2024.01.01 – 2024.12.31	90
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөн ажиллаж байна.	2024.01.01 – 2024.12.31	90

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нягтлан бодогч ГУБ
(Албан тушаал)

 / Б.Ганбат/
(Нэр, гарын үсэг)

2024 оны 12 дугаар сарын 05
(Огноо)

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ГАНБАТЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хяналт тавьсан байдал	60	10	70	
2.	Байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргах, удирдлагыг мэдээллээр хангасан байдал, аудит, хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн	55	5	60	
3.	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн	60	10	70	
4.	Албан хаагчдын нийтлэг баталгаа цалин хөлс, урамшуулал, илүү цаг, тэтгэмж гэх мэт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал	60	10	70	
5.	Төсөв, санхүүгийн шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	60	5	60	
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	60	10	70	
7.	Хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
8.	Үүрэг даалгаврын биелэлт	60	5	65	
9.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
10	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	55	5	60	
Дундаж оноо:				66.5	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	90	12	
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	90	12	
Дундаж оноо:				12

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	6	
2.	Асуудал шийдвэрлэх	6	
3.	Хариуцлагатай байдал	5	
4.	Дүн шинжилгээ хийх	6	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.	6	
Дундаж оноо:		6	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	
Дундаж оноо:		7

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	(70 хүртэлх оноо) 66.5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний	(15 хүртэлх

биелэлт	оноо) 12
3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 6
4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 7
5. Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо 91.5	

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

.....
(гарын үсэг) /Д.Долгорсүрэн/
(албан хаагчийн нэр)

2024. 12.10 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Гаалийн улсын байцаагч
(албан тушаал)

.....
(гарын үсэг) /Б.Ганбат/
(албан хаагчийн нэр)

2024. 12.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

.....
(гарын үсэг) /Г.Энхтайван/
(албан тушаал)

(гарын үсэг)

2024. 12.10 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн
Гаалийн улсын ахлах байцаагч

.....
(гарын үсэг) /Ө.Тэгшээ/
(албан тушаал)

(гарын үсэг)

2024. 12.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга
(албан тушаал)

..... /Р.Отгонжаргал/

(гаарын үсэг)

2024.12.20 (огноо)